



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Төв аймгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70272582
И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com
Факс: 01-272-22582

Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273465
И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Аудитор: Ц.Саранчимэг
Утас: 70273204
И-мэйл: tsaranchimeg@yahoo.com

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн Аудитын газрын хаяг:
Төв аймаг Зуунмод сум 6-р баг
Төрийн байгууллагуудын 2-р ордон
Цахим хуудас: tuv@audit.gov.mn

2017 оны 03 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, аудитын албаны төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-2017/196/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Санхүүгийн хяналт, аудитын албаны төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 03 дүгээр сарын 07-ныг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн Төв аймгийн Аудитын газрын санхүүгийн аудитын багийн гишүүн ахлах аудитор Ц.Саранчимэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 25-нд Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Төв аймгийн Аудитын газар аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 3 дугаар сарын 6-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дүгээр сарын 7-нд Санхүүгийн хяналт, аудитын албаны удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Төв аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь “Хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино” эрхэм зорилгын дор үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38 –д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг гэж заасны дагуу Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн ИТХурал баталж Төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Төв аймгийн Санхүү хяналт, аудитын алба –ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 27 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 1 асуудал эрсдэл өндөр, 6 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 21 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 1 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төв аймгийн Санхүү хяналт, аудитын алба өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 145665.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 0 төгрөгийн төсөв баталсан байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба 2016 онд 124665.0 мянган төгрөгийн санхүүжилт, нэмэлт санхүүжилт 16562.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан

орлого 1539.9 мянган төгрөгийн орлого олжээ. Үүнээс урсгал зардалд 141226.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Шилэн дансны мэдээлэл:

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2016 оны 10 сард хийгдсэн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгах нийцлийн аудитаар мэдээлбэл зохих 24 мэдээлэлийг бүрэн оруулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 6 чиглэлээр 21 эрсдэлтэй асуудалд 21 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 57 хувь буюу 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний нийт ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 100 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний 450.0 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн 450.0 мянган төгрөг тооллогын бүртгэл бүртгээгүй байна. Энэ нь ашиглалтанд ороогүй байгаа сайтыг бүртгэлд авсан байна. НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Гэрээгээр гүйцэтгэсэн ажлыг бүрэн дуусгаж, ажил хүлээлцсэн актыг үндэслэн хүлээн авч байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

2. Хөрөнгийн зардал бэлтгэх 8500.0 мянган төгрөг батлагдсанаас 9527.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж 1027.5 мянган төгрөгөөр хэтэрүүлсэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4-д Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Үндсэн хөрөнгө бэлтгэхдээ батлагдсан төсвийн хүрээнд бэлтгэж төсвийн хэтрүүлэн зарцуулахгүй байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3. Өглөгийн дансны оны эхний болон эцсийн үлдэгдэлийг журналд 216.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3-д Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1- анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2- журналд бичих, 14.3.3- дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4- ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5- санхүүгийн тайлан гаргах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Залруулга хийхээр шийдвэрлэв.

4. Өр барагдуулахаар аймгаас өгсөн дэмжлэгээс өмнөх оны томилолтын өглөгөөс 786.3 мянган төгрөгийг барагдуулж, 5326.5 мянган төгрөгийн томилолтын үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4-д Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ, 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн хуулийн үндсэн зарчмыг баримтлан төсвийг зохистой удирдаж өр авлагагүй ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад 216.0 мянган төгрөгийн алдаа залруулагдсан болно. Материаллаг бус 6354.0 мянган төгрөгийн алдаа залруулагдаагүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн аудитаар албан томилолтын зардалд анхаарал татахуйц асуудал байгаа гэж үзэж шалгахад тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 6804.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс материаллаг бус 216.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 6588.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Санхүүгийн хяналт, аудитын албаны төсвийн 2015 оны санхүүгийн тайланд аудит хийж 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн хариуг албан бичгээр Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР**

**Л.ЖАРГАЛСАЙХАН
О.АМАРЖАРГАЛ**

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ц.САРАНЧИМЭГ

Огноо: 2017.03.07